



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 145

Булагтай

Сум хөгжүүлэх сангийн 2019 оны төсвийн гүйцэтгэл,
2020 оны төсвийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18-р зүйлийн 18.1.2-ын "б", Засгийн Газрын 2016 оны 153-р тогтоолын 1 дүгээр хавсралтын гуравдугаар бүлгийн 3.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 28 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн 2020 оны төсвийн нийт дүнг 28000,0 мянган төгрөгөөр тогтоож, орлого /эргэн төлөлт/-ын хуваарийг дор дурдсанаар баталсугай.

№	Сум хөгжүүлэх санд төвлөрөх орлого	Дүн /мян.төг/
1	Сум хөгжүүлэх сангийн төсвийн нийт дүн /1=2+3+4/	48000,0
2	Сангаас олгогдсон зээлийн хүүгийн нийт дүн /2020 онд орох хүү/	2000,0
3	Сангийн зээлийн эргэн төлөлтийн нийт дүн /2020 онд төлөгдөх/	46000,0
	Төлөгдсөн мөнгөн дүн	2000,0
	1-р улиралд төвлөрөх зээлийн эргэн төлөлт	11000,0
	2-р улиралд төвлөрөх зээлийн эргэн төлөлт	11000,0
	3-р улиралд төвлөрөх зээлийн эргэн төлөлт	11000,0
	4-р улиралд төвлөрөх зээлийн эргэн төлөлт	11000,0

2. Сум хөгжүүлэх сангийн 2020 оны зардал, зээл олголтын хэмжээг дор дурдсанаар баталсугай.

д/д	Сум хөгжүүлэх сангаас зарцуулах зардал	ДҮН /мян.төг/
1	СХС-ийн зардлын нийт дүн /1=2+3/	48000,0
2	Зээлийн хэрэгжилтэд хяналт тавихад зарцуулагдах /хүүгийн 50%/ дүн	1000,0

	Үүнээс: Томилолт	300,0
	Шатахуун	270,0
	Бичиг хэрэг	230,0
	Бусад зардал /болзошгүй/	200,0
4	СХС-аас олгох зээлийн нийт дүн	47000,0
	2-р улиралд	23500,0
	3-р улиралд	23500,0

3. Зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төвлөрүүлэх, өмнөх жилүүдийн зээлийн үлдэгдлийг шуурхай барагдуулж сангийн хөрөнгийн эргэлтийг нэмэгдүүлэх ажлыг хяналтын ажлын хэсэгтэй хамтран зохион байгуулах, сангаас зээл хүссэн иргэдийн хүсэлтийг сайтар судлан шуурхай шийдвэрлэхэд анхаарч ажиллахыг сумын Засаг дарга /Д.Пүрэвдорж/-д, сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт тавих комисс /Т.Эрдэнэбат/-т нарт тус тус даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хагас жилээр хяналт тавьж, тайлан мэдээлэлтэй танилцаж чиглэл өгч ажиллахыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ